



**“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС  
ГИШҮҮН ЖАМБАЛСҮРЭН ОВОГТОЙ НАРАНТУЯАГИЙН 2022 ОНЫ  
1-Р ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН”**

Миний бие Ж.Нарантуяа нь Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс томилогдон ажилласнаас хойш өдгөө 8 дахь жилдээ хараат бус гишүүний чиг үүргээ биелүүлэн ажиллаж байна. 2022 оны 2-р улирлын байдлаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Хүний нөөцийн хорооны даргын үүргийг биелүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Богд банкны ТУЗ-ын дэргэдэх Хүний нөөцийн хороог 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ТУЗ-ийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх талаар, Аудитын хороог 3 удаа хуралдуулж, Хурлын даргаар миний бие Ж.Нарантуяа, гишүүд болох Л.Болдхуяг, Д.Моломжамц, Эллиот Рован Аукланд нар Аудитын тайлан болон бусад асуудлуудыг авч хэлэлцсэн.

Хороодын хурлуудад зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөөгүй, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж ажилласан.

ТУЗ-өөс зарлагдсан бүх ээлжит бус хуралд оролцон саналаа өгч ажилласан ба 2022 оны 2-р улирлын байдлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож уг хэлцлүүдийг батлахад зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан асуудал гараагүй болно.

Богд банк ХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу банкны засаглалын хэрэгжүүлэн хангалттай сайн ажиллаж байна. Удирдлагын баг, ТУЗ-ын гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хооронд харилцааны үл ойлголцол байхгүй, банкны шийдвэр гаргалт нэг албан тушаалтны хэт төвлөрөлгүйгээр зохих журмын дагуу явагдаж байна.

Заавал мөрдөх ёстой аливаа хууль, дүрэм журмыг зөрчсөн болон харилцагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр, үйлдэл банкны үйл ажиллагаанд

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Ж.Нарантуяа